

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРД
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.10.31

Сайншанд сум

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

/2022.10.06/ Дорноговь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 5 дугаар хуралдаан зохион байгуулагдлаа. Хуралдаанаар доорх асуудлуудыг хэлэлцэж баталсан.

1.Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэлийг бууруулах зорилгоор зохион байгуулсан “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээний тайлантай танилцах

2.Бүх төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис болон донтолт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус аймгийн Сайншанд, Зүүнбаян, Замын-Үүд, Айраг, Даланжаргалан сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн нарийн мэргэжлийн эмчийн сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөтэй танилцах

3.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороод, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хяналт шалгалт хийх, үүрэг чиглэл өгөх зорилгоор сумдад ажиллах ажлыг төлөвлөгөөг хэлэлцэж батлах

4.Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах, үр дүнгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болголоо.

/2022.10.06/ Аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурал 85%-ийн ирцтэйгээр хуралдаж, доорх асуудлыг хэлэлцэн баталлаа.

1.Аймгийн Эрүүл мэндийн газар болон Нэгдсэн эмнэлэгт өгсөн чиглэлийн хүрээнд зохион байгуулсан ажлын талаарх мэдээллийг сонсох

2.Аймгийн ИТХ-ын Хороодын сумдад ажиллах ажлын хэсгийн хуваарийг зөвлөлийн гишүүдэд танилцуулах

3.Аймгийн ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдааны тов тогтоох тухай хэлэлцэж, ээлжит хуралдааныг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулахаар товлосон.

/2022.10.07/ Аймгийн ИТХ-ын дарга, ГХУСАЗСЗ-ийн дарга Б.Ганзориг аймгийн Цагдаагийн газарт ажиллаж, аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааны тайлан мэдээтэй танилцлаа. Мөн энэ үеэр аймгийн Цагдаагийн газарт мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хэвийн болгох, иргэнд лавлагаа олгох үйлчилгээг шуурхай болгох, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сүлжээний замчлагч төхөөрөмж, Согтууруулах ундааны зүйл хэрэглэж замын хөдөлгөөнд оролцсон зөрчлийг илрүүлж учирч болох хор уршгаас урьдчилан сэргийлэх, зам тээврийн ослыг бууруулах, үүнээс үүдэлтэй нас баралт, гэмтэл, хохирлыг багасгах зорилгоор согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах төхөөрөмж, Мөрдөн

байцаах тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах, хэргийн газрын нотлох баримтыг бүрдүүлэхэд ашиглах тоног төхөөрөмж, мөн аймгийн хэмжээнд ажиллаж байгаа олон нийтийн цагдаа нарт өвөл, зуны иж бүрэн хувцас, хамгаалах хэрэгслийг гардуулан өгсөн.

/2022.10.13/ Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрөөр ахлуулсан ажлын хэсэг ажиллалаа.

Дорноговь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга бөгөөд салбар комиссын нарийн бичгийн дарга Ц.Батсугир Монгол улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны гишүүдийг хүлээн авч аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй Цагаатгалын ажлын үйл явц, Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг танилцууллаа.

Дорноговь аймгийн салбар комиссоос 2022 оны 3 дугаар улирлын цагаатгалын тайлан мэдээ, Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх 27 дахь өдрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулсан бөгөөд Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх "НОГООН ТӨГӨЛ"-ийг Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнд байгуулж, тохижуулсан юм.

/2022.10.18/ Дорноговь аймгийн ИТХ-ын ээлжит 09 дүгээр хуралдаан зохион байгуулагдлаа. Хуралдаанаар доорх асуудлуудыг хэлэлцэн батлав.

- 1.Дорноговь аймгийн төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр батлах тухай
- 2.Аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээг батлах тухай
- 3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтэд санал авах тухай
- 4.Аймгийн 14 сумын 65 багийн оноосон нэр батлах тухай
- 5.Аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай
- 6.Бусад асуудал

/2022.10.19/ Дорноговь аймгийн ИТХ-ын хороод болон ГХУСАЗСЗ-ийн гишүүдийн хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022.10.19-2022.10.27-ны өдрүүдэд 14 суманд ажиллалаа.

- 1.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай танилцах
- 2.Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангаж байгаатай танилцах
- 3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй танилцах
- 4.Сумдад 2022 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилтийн явцтай танилцах
- 5.Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай танилцах

6.Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт, төслийн хэрэгжилттэй танилцах

7.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн биелэлттэй танилцах

8.Усны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн хэрэгжилттэй танилцах

9.Газрын тухай хууль тогтоомжийн биелэлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах, ИТХ-аас батлан гаргасан тогтоол шийдвэрийн биелэлттэй танилцах

10.Сумдын ИТХ-ын үйл ажиллагаатай танилцаж, үүрэг чиглэл өгөх
Аймгийн ГХУСАЗСЗ-аас хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд:

1.Сумдын ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөний биелэлтийг шалгах, танилцах, үүрэг чиглэл өгөх

2.Сумдын "Хамтарсан баг"-уудаас хүүхэд хамгааллын чиглэлээр зохион байгуулсан ажлын явц, үр дүн, хэрэгжилттэй танилцах

3.Цагдаагийн хэсгийн үйл ажиллагаа, 2022 оны байдлаар зохион байгуулсан ажлын явц, үр дүн, хэрэгжилттэй танилцах

4.Иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын явц, үр дүн, хэрэгжилттэй танилцах

5.Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын явц, үр дүн, хэрэгжилттэй танилцах

Сумын иргэд, төрийн албан хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж аймгийн ИТХ-ын болон ГХУСАЗСЗ-аас хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг танилцуулах

Иргэд, олон нийтийн байгууллагын санал, гомдол, мэдээллийг хүлээн авах чиглэлүүдээр ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын даргын шагнал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр 4, “Өргөмжлөл”-өөр нийт 31 иргэнийг шагнаж урамшуулсан байна.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж

Аймгийн ИТХ-ын даргын нийт 16 захирамж гарснаас Буцалтгүй тусламж олгох тухай-1, Зардал гаргах тухай-1, Шагнах тухай-4, Хүндэтгэл үзүүлэх тухай-2, Дэмжлэг үзүүлэх тухай-7, Ээлжит хуралдааны тов тогтоох тухай-1 захирамж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн 3 тушаал гарсан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Хүний нөөцийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйл ажиллагааны тушаал 5, боловсон хүчний тушаал 2 баталсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчигээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж байна.

“Дорноговь аймгийн Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилтод хөтөлбөр”-ийг боловсруулж аймгий ИТХ-ын 2022.10.18-ны өдрийн 08 дугаар хуралдаанаар хээлцүүлэн батлуулсан.

Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг боловсруулан, авч дүгнэсэн.

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А- 59, Захирамж Б- 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А- 5, Тушаал Б-2 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 59 А Захирамжийг сайтад байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 513 албан бичиг ирснээс 15 нь хугацаатай албан бичиг ирсэн. Үүнээс 4 албан бичиг хугацаа болоогүй бусад 11 албан бичиг хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Бусад байгууллагад явуулсан 82 албан бичиг гарсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2022.10.18-ны өдрийн 08 дугаар хуралдаанаар “Аймгийн 14 сумын 65 багийн оноосон нэр батлах тухай” тогтоолыг батлуулсан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулах, “Хөгжлийн төлөө хамтдаа-II” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Төрийн анхан шатны нэгж дэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн бүтээмжийн сэргэлтийг хэрэгжүүлэх нь” сэдэвт “Багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалт”-ыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 2022 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд 65 багийн Засаг даргыг хамруулан зохион байгуулсан. Сургалтад дараах чиглэлийн багц мэдээллийн хүрээнд 15 агентлаг байгууллагын мэдээлэл, танилцуулга хүргэсэн. Үүнд:

- Төрийн бодлого, нутгийн удирдлага
- Бүртгэл, статистик
- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх аргагүй

- Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь Сургалтын төгсгөлд “Сургалтын үнэлгээний хуудас”-ыг оролцогчдоос үнэлгээ, дүгнэлт, санал авсан. Үнэлгээний хуудсыг 57 хүн бөглөж ирүүлснээс сургалт 81,2%-ийн үр дүнтэй гэж дүгнэсэн. Мөн Багийн Засаг дарга нарын дунд Нөхөрсөг тэмцээнийг спорын 4 төрлөөр зохион байгуулсан.

Сумдад зохион байгуулагдсан томоохон ажлаас:

Аймгийн 14 суманд цэрэг татлагын ажил зохион байгуулагдсан.

Түүх соёлын биет өвийн тооллого зохион байгуулагдсан.

Өргөдөл, гомдол, шагнал:

Энэ сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж 38 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс:

Бичгээр -20,

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – 17

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар болон <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар – 1 өргөдөл санал ирсэн байна.

Ирсэн нийт өргөдөл, гомдол, саналууд 35 нь шийдвэрлэгдэж, 3 өргөдөл шийдвэрлэхээр судлагдаж байна.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 27 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч дэмжих санал авахаар харъяалах төрийн төв байгууллагад хүргүүлж, дэмжсэн санал ирсэн шагналын материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 86 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргын “Жуух”-аар 20 иргэнийг, “Өргөмжлөл”-өөр 48 иргэнийг шагнах тухай захирамж боловсруулж батлуулав.

Гадаад харилцааны чиглэлээр:

Сайншанд хот болон БНХАУ-ын Сичуань мужийн Пенжоу хот хооронд байгуулах санамж бичгийн төслийг ГХЯ.ны гэрээ эрх зүйн газарт зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.

Турк улсын Сакаръя хоттой хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх зорилгоор албан бичгээр санал боловсруулан хүргүүлсэн.

Эрхүү мужтай байгуулах хамтын ажиллагааны Санамж бичигт зөвшөөрөл авахаар ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрхзүйн газарт хүргүүлсэн.

Япон улсын Шизуока муж хооронд зохион байгуулалдаг “Сурагч солилцооны хөтөлбөр”-ийн хүрээнд 25 хүүхэд явахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж байна.

АНУ-ын Элчин Сайдын Яамны Консулын хэлтсийн 3 ажилтан Сайншанд хотод 2022 оны 10-р сарын 27-28-ны өдрүүдэд ажиллан аймгийн удирдлагатай уулзалт зохион байгуулж, Өргөн сум дахь “Мон цемент” үйлдвэртэй танилцсан.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн албан хаагчдыг чадавхжуулах 2 дугаар ээлжийн сургалтад хамрагдах 6 албан хаагчдын мэдээллийг Шизүока мужийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-ын цаг үеийн 80 мэдээ аймгийн сайт болон цахим хуудсанд байршуулсан.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 15 байгууллагын 34 албан хаагчид өгч ажилласан.

ЦЭРГИЙН ШТАБ:

Дорноговь аймгаас 2021 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан Зэвсэгт хүчний 013, 029, 032, 336, Хилийн цэргийн 0184 дүгээр ангиудад алба хаасан түрүүч, байлдагч нар 10 сарын16-17-ны өдрүүдэд халагдаж ирсэн бөгөөд цэрэг дайчдыг угтан авах ёслолын ажиллагаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга хатагтай Н.Хонгорзул, Цэргийн штабын дарга дэд хурандаа М.Амартүвшин нар оролцож үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн дайчдад баяр хүргэж гарын бэлэг гардуулсан.

Дээрх үйл ажиллагааны үеэр Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа болон цэргийн гэрээт албыг сурталчлах, хугацаат цэргийн алба хаасан залуучуудыг ажлын байранд зуучлах ажлуудыг зохион байгууллаа.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГА ЯВУУЛСАН ТУХАЙ

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны н/220 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар 2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 09-ний өдрүүдэд Замын-Үүд, Эрдэнэ, Өргөн, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Даланжаргалан, Айраг, Сайншанд сумдын цэргийн насны залуучуудыг хамруулан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 144, 441 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулан явууллаа.

1.Цэрэг татлагын талаар:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/609 дүгээр захирамжаар томилогдсон Цэрэг татлагын товчоо нь 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд аймгийн Биеийн тамир спортын газарт тус оны хоёрдугаар ээлжийн цэрэг татах ажлыг зохион байгуулж явууллаа.

Хугацаат цэргийн албаны татлагаар Монгол улсын Засгийн газрын 2017 оны 144, 441 дүгээр тогтоолын “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр

тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам"-ийн дагуу аймгийн Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад, нэгдсэн татлагаар ажиллахдаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлж, нэг дор 5-аас дээш иргэн цуглуулахгүй, иргэн хоорондын зайг 1,5-2 метр байхаар төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн цэргийн албанд татагдагч иргэдэд гар ариутгагч, амны хаалт /маск/-г тогтмол зүүлгэж эрүүл ахуйн халдваргүйжүүлэлтийн дэглэмийг горимын дагуу чанд сахиулан ажилласан.

2.Мэдээлэл сурталчилгааны ажлын талаар:

Цэрэг татлагын бэлтгэл ажлын үеэр аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, багийн Засаг дарга нар, бүртгэл мэдээллийн ажилтнуудын бүрэлдэхүүнд сургалт семинарыг 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулан мэдээ, мэдээллийг өгч ажиллалаа. Цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгээр сумдад Батлан хамгаалахын хууль тогтоомж, цэргийн албаны тухай хууль, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчилж, иргэдээс гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүрд шийдвэрлэн хариу өгч ажилласан. Аймгийн DSB, DTV телевизүүдэд мэдээний цаг захиалж 10 минутын хугацаатай иргэн цэргийн жинхэнэ алба хаах хууль тогтоомжийн талаар сурталчилгаа мэдээ, мэдээллүүд бэлтгэж нэвтрүүлсэн.

Дүгнэлт:

Цэргийн жинхэнэ албанд татагдагч нарыг Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ийн 5 дугаар хавсралтад заасны дагуу цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр удаа дараа ээлжит цэрэг татлагаар тэнцэхгүй, 18-25 насны иргэдийг тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй акт, дүгнэлтийг цэргийн нарийн мэргэжлийн эмч нараар тогтоолгох шаардлагатай.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон Цэрэг татлагын товчоо нь хууль тогтоомжийн дагуу цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, үүргээ сайн гүйцэтгэж хуваарьт Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангид цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэдийн хяналтын тоог бүрэн биелүүлсэн

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Цагдаагийн газрын мэдээ:

Нэг. Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц

Аймгийн Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нэр дээр тухайн сард хийж гүйцэтгэсэн ажил болон 7 хоногийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээг тус тус албан бичгээр хүргүүлж ажилласан.

Хоёр. Цаг үеийн болон урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл

Иргэдийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ихэсдэг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох,

яллагдагчаар татах этгээд нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх, оргон зайлсан болон гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдүүдийг олж тогтоох зорилгоор Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл 51 хоногийн хугацаанд зохион явуулж байгаа “Илрүүлэлт Оргодол 2022” нэгдсэн арга хэмжээнд Дорноговь аймаг дахь цагдаагийн газар нь арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Оргодол 8, Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 30, Шүүхээс даалгасан этгээд 23, Зөрчил үйлдсэн этгээд 8, Сураггүй алга болсон хүн 2, Тээврийн хэрэгсэл 7-г олж тогтоосон. Мөн мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлсэн 39 эзэн холбогдогч нь тодорхойгүй гэмт хэргийг илрүүлэн ажилласан.

Тус аймгийн Сайншанд сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн А/298 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сайншанд суманд ахуйн хүрээндээ болон гудамж талбай олон нийтийн газар ойр орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг архины хамааралтай 42 иргэдийн судалгааг багийн Засаг дарга, хорооны ажилтнуудтай хамтарч гарган 28 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт 2022 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд 9 төрлийн шинжилгээ үйлчилгээнд хамруулан “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль”-ийн дагуу эмчийн дүгнэлтийг үндэслэн материалжуулан Шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уулзалтын үеэр ахмад ажилтнуудыг хүн нэг бүрээр нь залуу алба хаагч нарт танилцуулсан. Цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч М.Лундаажанцан залуу алба хаагчдад өөрийн туулж өнгөрүүлсэн ажлын туршлагаасаа хуваалцсан. Хөтөлбөрийн дагуу ахмад ажилтнуудад Ханшонхор ресторанд үдийн зоог барьж арга хэмжээг хаан цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Пүрэвдэлгэр ахмад ажилтан С.Осгонбаатар, Х.Гэрэлбаатар, М.Лундаажанцан, Н.Эрдэнэ-Очир, Ц.Цэвээндорж нарт “Шилдэг аймаг 90” тэмдэг, Д.Жаргалд “Монгол Цагдаа” медалийг тус тус гардуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/1422 дугаар тушаалаар тус хэлтсийн Эрүүлжүүлэх саатуулах байрны эмч, цагдаагийн хошууч Ю.Жавзантуяа цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсантай холбогдуулан цагдаагийн хэлтсээс хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион явуулсан. Цагдаагийн бэлтгэл хошууч Ю.Жавзантуяад хэлтсийн алба хаагчдаас дурсгалын зүйл ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн.

Цагдаагийн хэлтсийн баг тамирчид ахмадын багтай “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг Хилийн цэргийн 0108-р ангийн спорт зааланд зохион явуулж 1 дүгээр байранд Ахмадын баг, 2 дугаар байранд Хийморь баг, 3 дугаар байранд Соёмбо баг тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын дунд “Буухиа” хөгжөөнт тэмцээний удирдамжийн дагуу хэлтсийн баг тамирчидын дунд тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, алба хаагчдын эрүүл мэнд, хамт олоны уур амьсгалыг нэгтгэх зорилгоор хөгжөөнт “Буухиа” тэмцээнийг биеийн тамир спортын багуудын хооронд зохион явууллаа. Баг тамирчдаас 5 алба хаагч 5 даалгаварыг хамгийн богино хугацаанд гүйцэтгэж бага онооны системээр дүгнэж байр эзлүүлсэн. Багуудаас нийлбэр дүнгээр 1-р байранд “Хийморь” баг 2 мин 15

сек 37 доль, 2-р байранд “Соёмбо” баг 2 мин 19 сек 10 доль, 3-р байранд “Хурд” баг 2 мин 22 сек 17 доль, 4-р байранд “Хүч” баг 2 мин 25 сек 96 доль, 5-р байранд “Шонхор” баг 3 мин 04 сек 32 долын амжилтаар тус тус байр эзэлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас зохион байгуулагдсан “Хандлага дор хүндлэл оршино” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд алба хаагчдыг хамарсан дараах ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:

"Урам хайрлах өдөр", "Талархалын үг" ил захидал солилцох ажлыг зохион байгуулсан.

Тус Цагдаагийн газраас нөлөөллийн аяны хүрээнд зохион байгуулагдаж буй Талархалын 7 хоногийг тохиолдуулан цагдаагийн газрын алба хаагчдад талархах, урам хайрлах зорилгоор “Өдрийн цай” арга хэмжээг зохион байгууллаа.

Талархалын 7 хоногийг тохиолдуулан "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, алба сурталчилах өдөр" арга хэмжээг зохион байгуулсан.

"Тамхигүй өдөр"-ийг зохион байгуулан хор нөлөөллийн талаарх мэдээллийг цагдаагийн газрын алба хаагчдад хүргэж, Хорт зуршлаас татгалзаж сайнаар үлгэрлэе аянг өрнүүлж, эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл хийлгэлээ.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2022 оны 3 дугаар улирлын “Сахилга, ёс зүйн зөвлөгөөн”-ийг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажилласан.

Тус Цагдаагийн газраас 2022 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын хамгаалалтын үйл ажиллагаанд аймгийн засаг даргын захирамжийн дагуу хяналт тавьж, хамгаалалт зохион байгуулагдсан.

Тус аймгийн 14 сумдын 65 багийн Засаг дарга нарын 2022 оны нэгдсэн уулзалт зөвлөгөөн зохион байгуулагдаж цагдаагийн газраас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч хамтран ажиллах чиглэлээр зааварчилга, зөвлөмж өгч ажилласан.

Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2022 оны 5/374 дугаартай үүрэг, Цагдаагийн хүрээний даргын 2022 оны А/53, Цагдаагийн газрын даргын 2022 оны “Өвлийн улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэх тухай” тушаал гарсантай холбогдуулан тус газраас жагсаалын үзлэгийг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Отгонтэнгэр нь Монгол улсын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах Гандболын тэмцээнд Дорноговь аймгийн баг тамирчдын хамт амжилттай оролцож мөнгөн медаль хүртсэн амжилт гаргасан.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулагдаж байгаа "Илрүүлэлт оргодол-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд "Уусан бол бүү жолоод" хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, Арга хэмжээний хүрээнд 42 чиглэлд 78 алба хаагчид үүрэг гүйцэтгэж хяналт шалгалтыг эрчимжүүлсэн арга хэмжээний хүрээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 17 зөрчил, эрхийн үнэмлэхгүй 14 нийт 31 зөрчил дутагдалыг илрүүлж, шийдвэрлэсэн.

Гурав: Гэмт хэрэг, зөрчлийн талаар:

Аймгийн хэмжээний гэмт хэрэг, зөрчлийн талаарх статистик мэдээ албан бичгээр хүргэгдэнэ.

Дөрөв. Ирэх сард зохион байгуулах гол ажлын тухай товч мэдээлэл, санал

1. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг:

Шийдвэр гүйцэтгэх тасаг нь иргэний шийдвэр гүйцэтгэх чиглэлээр ирүүлсэн үүрэг, албан даалгаврын дагуу тодорхой төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэлийн 4 тойрогт 4 шийдвэр гүйцэтгэгч, жолооч гэсэн 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй эрүү, иргэн, захиргааны, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр: 2021 оны эхний үлдэгдэл 233 гүйцэтгэх баримт бичгийн 3372662,4 төгрөгийн төлбөр дээр шинээр шүүхээс 2577606,0 төгрөгийн үнийн дүнтэй 386 гүйцэтгэх баримт бичиг, харьяаллын дагуу алба хооронд 79036,5 төгрөгийн үнийн дүнтэй 7 гүйцэтгэх баримт бичиг, түдгэлзүүлснийг сэргээсэн 485830,3 төгрөгийн үнийн дүнтэй 17 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор 731618,9 төгрөгийн үнийн дүнтэй 75 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлж, газар хооронд 141337,2 төгрөгийн үнийн дүнтэй 12 гүйцэтгэх баримт бичиг шилжүүлж нийт гүйцэтгэвэл зохих 5150655,2 төгрөгийн үнийн дүнтэй 555 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 597508,0 төгрөгийн үнийн дүнтэй 224 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 359955,8 төгрөгийн үнийн дүнтэй 163 гүйцэтгэх баримт бичигт хэсэгчилсэн төлөлт хийж тайлант хугацааны эцэст 4193191,4 төгрөгийн үнийн дүнтэй 331 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажилласан.

Тайлант гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 40,4 хувьтай байна.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭРТЭЙ

Иргэний шүүхийн шийдвэртэй 2021 оны эхний үлдэгдэл 2037334,5 төгрөгийн үнийн дүнтэй 164 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 2673914,0 төгрөгийн үнийн дүнтэй 237 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 599786,7 төгрөгийн үнийн дүнтэй 26 гүйцэтгэх баримт бичгийг хасч, гүйцэтгэвэл зохих 4111461,8 төгрөгийн үнийн дүнтэй 375 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 708009,2 төгрөгийн үнийн дүнтэй 129 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож тайлант хугацааны эцэст 3403452,6 төгрөгийн үнийн дүнтэй 246 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацааны эцэст гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 34,4 хувьтай байна.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШИЙДВЭРТЭЙ

Эрүүгийн хэргийн шийдвэртэй 2021 оны эхний үлдэгдэл 536994,7 төгрөгийн үнийн дүнтэй 42 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 394351,4 төгрөгийн үнийн дүнтэй 134 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 255874,1 төгрөгийн үнийн дүнтэй 58 гүйцэтгэх баримт бичгийг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор түдгэлзүүлж, гүйцэтгэвэл зохих 656381,5

төгрөгийн үнийн дүнтэй 113 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 152155,2 төгрөгийн үнийн дүнтэй 55 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож тайлант хугацааны эцэст 504226,3 төгрөгийн үнийн дүнтэй 58 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 48,7 хувьтай байна.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШИЙДВЭРТЭЙ

Захиргааны хэргийн шийдвэртэй шүүхээс шинээр 2823,5 төгрөгийн үнийн дүнтэй 9 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 2823,5 төгрөгийн үнийн дүнтэй 5 гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгож 4 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 55,6 хувьтай байна.

ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ШИЙДВЭРТЭЙ

Зөрчлийн хэргийн шийдвэртэй шүүхээс шинээр 5900,0 төгрөгийн үнийн дүнтэй 22 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 5900,0 төгрөгийн үнийн дүнтэй 22 гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгож гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 100 хувьтай байна.

БУСАД ХЭРГИЙН ШИЙДВЭРТЭЙ

Бусад хэргийн шийдвэртэй 2021 оны эхний үлдэгдэл 307809,3 төгрөгийн үнийн дүнтэй 27 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 81709,1 төгрөгийн үнийн дүнтэй 15 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 89775,9 төгрөгийн үнийн дүнтэй 17 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож тайлант хугацааны эцэст 285512,5 төгрөгийн үнийн дүнтэй 23 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 42,5 хувьтай байна.

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛГИЙН ТӨЛБӨР БАРАГДУУЛАЛТЫН ТАЛААР:

2021 оны эхний үлдэгдэл 309233,3 төгрөгийн үнийн дүнтэй 269 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 522137,3 төгрөгийн үнийн дүнтэй 46 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, 70,2 төгрөгийн үнийн дүнтэй 1 гүйцэтгэх баримт бичиг газар хооронд харьяаллаар шилжүүлж, гүйцэтгэвэл зохих 831300,4 төгрөгийн үнийн дүнтэй 312 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 86320,7 төгрөгийн үнийн дүнтэй 38 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 183 гүйцэтгэх баримт бичгийн 387245,4 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, тайлант хугацааны эцэст 357734,3 төгрөгийн үнийн дүнтэй 274 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж гүйцэтгэх баримт 12,1 хувь мөнгөн дүн 57 хувьтай байна.

БУСАД АЖИЛ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Өр төлбөргүй тухай лавлагаа гаргуулахаар хүсэлт ирүүлсэн 7 хуулийн этгээдэд холбогдох лавлагаа мэдээллийг гарган өгч ажиллалаа

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон-Алт” төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото

мониторингийн аргаар үнэлэх” ажлыг Дорноговь аймгийн 14 сумын нутаг дэвсгэрт 228 цэгт хээрийн судалгааг гүйцэтгэсэн.

Судалгаагаар аймгийн нийт нутгийн аймгийн нийт нутгийн 39.5 хувь нь 50-100 хүртэлх хувийн бэлчээрийн нөөцтэй, 34.4 хувь нь бэлчээрийн даац 1-3 дахин, 7.5 хувь нь 3-5 дахин, 18.4 хувь нь олон дахин хэтэрсэн гэж тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл 2022-2023 оны өвөл, хаврын улиралд бэлчээрийн даац нийт нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, 60 гаруй хувьд хэтрэлттэй гарсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 09 дүгээр албан даалгавар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан даалгавар, аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавар тус тус гарч, аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил 81.5 хувьтай эцэслэсэн.

2021 оны жилийн эцэст тус аймагт малтай 5824 өрх тоологдсны 4665 өрх буюу 80.1 хувь нь малчин өрх, 1159 өрх буюу 19.9 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж байгаа ба нийт 2706,7 мянган толгой мал тоологдсон нь урьд оноос 5 төрөл дээрээ нийт 6,1 хувь буюу 155,2 мянган толгойгоор өссөн.

Аймгийн хэмжээнд 2022-2023 онд 3,0 сая орчим толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөв гарсан. Үүнээс хилийн зурваст 6 сумын 148 өрхийн 124,7 мянга, сум дундын отрын бүс нутагт 1 сумын 2 өрхийн 2,1 мянга, тусгай хамгаалалттай газар нутагт 2 сумын 164 өрхийн 80,2 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан судалгаа гарсан.

Малын тарга хүч **дундаас дээш** орсон ба хүн амын хүнсний хэрэгцээнд болон зах зээлд нийт 434,6 мянган толгой мал нийлүүлэх тооцоо гарсан байна.

Тус аймагт аймаг дундын отрын бүс нутаг байхгүй хилийн зурваст 6 сумын 148 өрхийн 125 мянган толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 2 сумын 164 өрхийн 103,7 мянган толгой мал нийт 312 өрхийн 228,7 мянган толгой мал хилийн зурваст болон улсын тусгай хамгаалалттай бүс нутагт отроор өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвтэй байна.

Өөр аймгийн нутагт 8 сумын 58 өрхийн 41,3 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 7 сумын 322 өрхийн 156,9 мянган толгой мал, сум дундын отрын бүс нутагт 1 сумын 2 өрхийн 2,1 мянган толгой мал намаржиж байгаа бол гадны 2 аймгийн 3 өрхийн 886 толгой мал намаржиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, 14 сумын аюулгүйн нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл тус тус бэлтгэхээр тогтоосон.

Өнөөдрийн байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 250.0 тн өвс, 61.5 тн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 580.6 тн өвс, 171.4 тн үйлдвэрийн тэжээл, малчдын түвшинд 4322.0 тн өвс, 531.0 тн үйлдвэрийн тэжээл, 42.0 тн гар тэжээл, 58.0 тн ногоон тэжээл, 322.0 тн давс хужир шүү бэлтгээд байна.

Аймгийн хэмжээнд бэлчээрт нийт 3202 худаг ашиглагдаж байгаа нь нийт бэлчээрийн 40,3 хувийг усжуулж байна. Тус онд улсын төсвийн 157,5 сая төгрөгийн хөрөнгөөр 5, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Хатанбулаг сумд СОНХС-ийн 161,5 сая төгрөгийн хөрөнгөөр 12, малчид хувийн хөрөнгөөр 9, нийт 26 инженерийн

хийцтэй худаг шинээр гаргаж, 10,5 мянган га бэлчээр усжуулж, 12,0 мянган толгой мал услах боломжийг бүрдүүлсэн.

Аймгийн хэмжээнд 217 өрх, 23 аж ахуйн нэгж 24,07 га талбайд төмс, 59,0 га талбайд хүнсний ногоо, 15,20 га талбайд жимс, жимсгэнэ, 33,9 га талбайд малын тэжээлийн ургамал, нийт 132 га талбайд тариалалт хийсэн. Ургац хураалтад 220 гаруй иргэн, 63 бага оврын трактор, 4 төмс ухагч ажилласан. Ургац хураалтын эцсийн дүнгээр 123,9 тн төмс, 403,0 тн хүнсний ногоо, 1,48 тн жимс, жимсгэнэ, нийт 528,3 тн ургац хураан авч, өмнө оноос хураан авсан ургацын хэмжээ 29,1 хувиар нэмэгдлээ. Аймгийн хэмжээнд 900 тн-ын багтаамжтай 21 зоорь хэвийн ашиглагдаж байна. Иххэт, Эрдэнэ, Даланжаргалан, Өргөн, Дэлгэрэх сумдад 33.9 га талбайд ногоон тэжээл тариалж, 18,5 тн ургац хураан авсан. Ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор давхардсан тоогоор 612 малчид, иргэдэд мэдээлэл өгсөн.

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас хөнгөлөлттэй зээл хүссэн аж ахуйн нэгжүүдийн төслийг “Төсөл сонгон шалгаруулах хороо” холбогдох хууль, журмын шаардлага хангасан 4 төслийг эрэмбэлэн ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээний саналыг аймгийн ИТХ—аар батлуулж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.

Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан “Хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгүүдийн ирүүлсэн саналыг нэгтгэн “Аймгийн жилийн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан.

Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын гишүүд Замын-Үүд суманд Газрын тос боловсруулах үйлдвэрийн агуулах, Чөлөөт бүсэд Худалдаа үйлчилгээний барилга, Сайншанд суманд Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн газар шорооны болон хашаа барих ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, холбогдох үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын судалгааг гаргаж, Барилга хөгжлийн төвд цахимаар хүргүүлсэн.

Хатанбулаг сумын “Ханги хилийн боомтын суурьшлын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг”-ийг байгуулан, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, сумын Засаг дарга, ГХБХБГ-т чиглэл өгч ажиллалаа.

Газар эзэмшүүлэх, газар эзэмших эрх дуусгавар болгохоор ирүүлсэн 6 хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Сайншанд суманд 9 иргэнд эзэмшиж буй хашааны газрыг, 3 иргэнд шинээр газар өмчлүүлсэн

Хөрөнгө оруулалтын ажлын чиглэлээр:

Сумдаас аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэх ажлын санал, сумандаа 2023 онд ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын урьдчилсан жагсаалтыг мөн сумдын 2022 оны ОНХСангийн явцын гүйцэтгэлийн тайланг авч удидлагуудад танилцуулсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 19 ажлын гүйцэтгэлд 2,5 тэрбум төгрөг, 15 ажлын зохиогчийн хяналтын зардлын 49,4 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээсэн.

Энэ сард тендерт шалгарсан 4 аж ахуй нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгэж дууссан 3 ажлыг комисс хүлээн авсан. Мөн цахим тендерээр энэ оны батлагдсан ажлуудаас зарлагдаагүй буюу оролцогч ороогүй 5 ажлын тендерийг зарласан.

Хил гаальтай холбоотойгоор ажил гүйцэтгэж байгаа компаниуд гэрээ сунгах хүсэлт ирүүлсэнийг ГХБХГазраас дүгнэлт авч 5 ажилд гэрээний сунгалтыг хийж батлуулсан.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд Аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн тамгын газар, Дорноговь аймаг дахь тагнуулын хэлтэс, Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хяналтын хороотой хамтран “Таны эрх миний эрхээр хязгаарлагдана” эрх зүйн нэгдсэн сургалтыг 2022-10-22 ны өдөр салбарын хэмжээнд 2 дахь удаагаа танхимаар зохион байгууллаа. Сургалтанд аймгийн нэгдсэн эмнэлэг бо лон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, өрх сумдын эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүд 100 албан хаагч оролцож эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн АШУҮИС-н НЭМС-н багш мэргэжилтнүүд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба стресс менежмент сэдвээр 2 кридетийн сургалтыг зохион байгуулж 29 албан хаагч оролцов.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/606, А/629 дүгээр захирамжуудын дагуу улирлын томуугийн дэгдэлт, түүнээс гарч болзошгүй эрсдэл, хүндрэлээс сэргийлэх зорилгоор эрсдэлт бүлгийн 3-5 хүртэлх насны хүүхдүүдийг томуугийн дархлаажуулалтанд хамруулж байна. 2022 оны 10 сарын 28-ны байдлаар зорилтот бүлгийн томуугийн дархлаажуулалтанд 602 хүүхдийг хамруулж, хамралт 80.3 хувьтай байна.

“Эрүүл шүд - Эрүүл хүүхэд аймгийн дэд хөтөлбөр” - ийн хүрээнд шүдний эмчийн явуулын үзлэгийг хойд бүсийн 5 /Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ/ сумдад шүдний эмчийн явуулын үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт нийт 908 хүн хамрагдсан ба 670 /73.7%/ хүүхэд, цэргийн насны залуус 31 /3.4%/ байна. Нийт үзлэгээс эрүүл хүний тоо 72, өвчлөлтэй хүний тоо 836 байлаа. Үзлэгийн үеэр нийт 836 хүний өвчтэй 1063 шүдэнд эмчилгээ хийж, 306 шүдийг авсан ба 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлж, 355 /42.4%/ хүнийг бүрэн эрүүлжүүлсэн. Урьд оны мөн үеийнхээс эрүүлжүүлэлтийн хувь 28.3 нэмэгдсэн үр дүнтэй ажилласан. ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж 9 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 425 хүнийг хамруулан 3 төрлийн 186 ширхэг гарын авлага тараасан. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд Би эрүүл шүдтэй ” дэвжээ тэмцээнийг ЕБС - н 4 - 6 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Уг тэмцээнд Өргөн, Зүүнбаян, Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл зэрэг 6 сумдын 23 багийн 221 сурагчид оролцон авъяас чавдар, авхаалж самбаагаа сорилоо. Тэмцээнийг 651 багш, эцэг эх, сурагчид үзэж сонирхон хамтран ажиллаж, сумдын НЭМ-ийн хөтөлбөрийн зардлаас 1.531.000₮ төгрөг зарцуулсан. Тэмцээний дараа оролцсон сурагчид, эцэг эхчүүд, багш нарт шүдээ зөв угаах арга техникийг зааж сурган 8 төрлийн 486 ширхэг гарын авлага тараасан.

Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Политехник коллежийн эмчтэй хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хуваарь гарган 1 дүгээр курсын 67 хүүхдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ өвчин сэдвээр сургалт зохион байгуулсан.

"Хүүхдэд ээлтэй орон нутаг", "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жил, "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" арга хэмжээний хүрээнд Шүдний эмч нартай хамтран Сайншанд сумын 1, 10, 12, 14 дүгээр цэцэрлэгийн 288 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж багш, эцэг эх, асран хамгаалагч нарт шүдний өвчлөлөөс сэргийлэх зөвлөмж мэдээлэл өгсөн.

ЭМГ-ын даргын А/115 тушаалын дагуу Олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн сургалтыг АНЭ-ийн хүүхдийн тасгийн зөвлөх эмч Ц.Одончимэг, АШУҮИС-ийн салбар сургуулийн хүүхдийн эмч, багш Т.Энхмягмар нартай хамтран Мишээлт мана, Агатова, Талст зам ӨЭМТ-д зохион байгуулж Сайншанд 1,2,3,4,6,7,8 дугаар багийн төрөх насны болон 0-5 насны хүүхэдтэй, эцэг, эх, асран хамгаалагч нийт 123 хүнийг хамруулсан. Уг сургалтыг хөтөлбөрийн дагуу 12 сэдвийн хүрээнд явуулж оролцогчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн.

ӨЭМТ-үүдийн НЭМ-ийн зардлаас 2022.10.10-наас 13-ны өдрүүдэд ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны алба, лабораториос 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг манай аймагт ирж, Айраг сумын ЭМТ, АНЭ-ийн халдварт сүрьеэгийн эмнэлэг, Агатова ӨЭМТ, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, Борхойн наран ӨЭМТ-үүдийн сүрьеэгийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, арга зүйгээр хангаж, цаашид анхаарах шаардлагатай зүйлсийн талаар санал зөвлөмж өгч ажиллалаа.

ХӨСҮТ Тархвар судлалын заалтаар хийгддэг галзуугийн эсрэг дархлаажуулалтын 3 32 - дугаар улирлын хамралтын мэдээг нэгтгэн гаргаж, ЗӨСҮТ- д хүргүүлэв. Галзуугийн эрсдэлд өртөж, нохойн дуруулж, толгойн тус газраа олон тооны шарх авсан 7 настай хүүхдэд галзуугийн эсрэг иммуноглобулин эмчилгээг хийх шаардлагатай болсон тул Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 3 флакон галзуугийн эсрэг иммуноглобулин ийлдсийг захиалан, татан авч, Аймгийн нэгдсэн эмнэлэгт эмчилсэн.

2022 оны 10 дугаар сарын 1 2 - 1 4 - ний өдрүүдэд “Томуугийн үндэсний аравдугаар зөвлөгөөн” Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, “Томуу, коронавируст халдвар (КОВИД-19)-ийн харуулдан тандалтыг бэхжүүлэх, салбар хоорондын оролцоог нэмэгдүүлэх, томуугийн болзошгүй цартахлын бэлэн байдлыг хангах” зорилгийн дор ЭМЯ, яамны харьяа байгууллага, аймаг, нийслэлийн ЭМГ, ӨЭМТ, НЭ болон БШУЯ, ОБЕГ, ГЕГ-ын Хилийн хорио цээрийн газар, МХЕГ, АШУҮИС, аймаг, дүүргийн ЗДТГ, ОБГ, ЗӨСТ, ДЭМБ-ын төлөөлөл 400 гаруй мэргэжилтэн оролцож байна.

“Сүрьеэг устгах” дэлхийн стратегийн зорилтод хүрэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор олон улсын хамтарсан үнэлгээ хийгдсэн. 2 нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн диспансерүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, Сүрьеэгийн тохиолдлын мэдээллэх хуудсыг татан авч батлагдсан нийт 2 тохиолдлын өрхийн хавьтал болох 6 хүнийг хавьтлын үзлэгт хамруулсанаас шинэ тохиолдол илрүүлээгүй. Сүрьеэгийн сорьц тээвэрлэлт сайруулах төсөл-ийн хүрээнд 13 сумаас 9 хүний цэрний сорьцыг тээвэрлэснээс эерэг сорьц илрээгүй. 10 сарын байдлаар 24 шинэ сүрьеэг илэрч 100% эмчилгээ хяналтанд авч, 10000 хүн амд ногдох сүрьеэ 2.7% болж, өмнөх оны энэ үеэс 1.2% тохиолдлоор буурсан. Сүрьеэгийн эрт илрүүлэг, идэвхтэй үзлэгийг Хатанбулаг суманд зохион байгуулж 207 хүнийг хамруулж, асуумж судалгаа болон рентген шинжилгээ өгч рентген шинжилгээнээс өөрчлөлттэй илэрсэн 6 хүний цэрний шинжилгээг авч шинэ халдвар илрээгүй

Үе тэнгийн сургагч багш нарыг чадавхжуулж тэдний оролцоог идэвхжүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх замаар өсвөр үеийн хэнд үнэн зөв эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Үе тэнгийн сургагч багш чадавхжуулах” сургалтыг ЭМГ - ын сургалтын танхимд хөтөлбөрийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 25 - 26 - ны зохион байгууллаа. Сургалтад Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 3, 5 дугаар сургууль, Политехник

коллежийн нийт 46 үе тэнгийн сургагч багш хамрагдсан бөгөөд үүнээс чадавхжсан 8, шинээр бэлтгэгдсэн 38 сурагч байна. Сургалтаар “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, Гэр бүл төлөвлөлт, БЗДХ/ДОХ, “Амны хөндийн эрүүл мэнд”, Өсвөр насны сэтгэлзүйн онцлог, Анхны тусламж, Электрон тамхи, Үерхэл хайр дурлал зэрэг сэдвүүдээр мэдлэг олгосон. Сургалтын өмнө болон дараа сурагчдаас тест авч сургалтын өмнөх үнэлгээгээр оролцогчдын мэдлэгийн түвшин 46.9% байсан бол сургалтын дараа 77.4% болж 30.5%-иар нэмэгдсэн. Үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан Политехникийн коллежийн 1 дүгээр дамжааны нийт 8 бүлгийн 160 оюутнуудад “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдвээр 5 өртөөгөөр өртөөчилсөн сургалтыг зохион байгууллаа.

Коронавируст халдварын илрүүлэг, тандалт шинжилгээг 2 нэгдсэн эмнэлэг, 14 сумын эрүүл мэндийн төв, Ханги боомт, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 40 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд суурин 20 цэгүүдэд ажиллаж, 10 сард 2454 /түргэвчилсэн оношлуураар - 2217, Бх-ПГУ-237/ хийгдсэн байна. Коронавирус илрүүлэх хувилбарын шинжилгээнд Ханги, Замын-үүд сумын хилийн боомт ажиллаж амьдарч байгаа иргэдээс сар бүр түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч эерэг гарсан сорьцыг ХӨСҮТ-д илгээн хувилбар тогтоолгож, одоогоор 58 сорьцыг илгээсэн байна. 58 АЗДТГ, ЦГ, Сайншанд сумын ЗДТГ хамтран Сайншанд сумын 5 байгууллагын 263 ажилтан албан хаагчдад согтууруулах ундааны хор уршиг, “АА” бүлгийн талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. 263 “Байгууллагын эрүүл мэндийн ажилтан бэлтгэх” сургалтыг 34 байгууллагын 41 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

“Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоо”-нд 2022 оны 05 сарын 01-нээс 10 сарын 29-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд хамрагдвал зохих хүн амын 18.1% буюу 13030 иргэд хамрагдсан. Үүнээс 75.1% (9787)-ийг 0-17 насны хүүхэд, 24.9% (3243)-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна. Анхан ЭМТ-үүд 0-17 насны 25297 хүүхдэд үзлэгт хамруулахаас 9787 хүүхэд буюу 38.7%-ийг, НЭ-үүд нийт 46816 хүн хамруулахаас 3243 (6.9%) хүнийг хамруулж шинээр 322 өвчлөлийг илрүүлээд байна. “Урьдчилан сэргийлэх үзлэгийг эрчимжүүлэх” 3 сарын аянг 08 дугаар сарын 23-аас 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд анхан шатны 1407 ЭМТ-үүд дунд зохион байгуулж байна. Аяны хугацаанд нийт 2542 хүүхэд нийт буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 10.0 хувийг хамруулсан ба нийт хамрагдвал зохих 0-5 насны хүүхдийн 25.9 (2038) хувь, 6-17 насны хүүхдийн 2.8 (504) хувийг хамруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугар сарын 07-ны өдрийн А/623 дугаар захирамжийн дагуу Сайншанд сумын 2, 3, 4, 5, 6, 9, 10, 14 дүгээр цэцэрлэгүүдэд 5 чиглэлийн дагуу хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн. 8 цэцэрлэг Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалт, ПТК-ийн оюутнууд, Цагдаагийн газар, Замын-4, Музей 5 газарт “Эрүүл хүнс, зохистой хооллолт”, “Хөдөлгөөн эрүүл мэнд” сэдвээр 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 584 ажилтан, оюутануудыг хамруулсан.

Хийн дасгалын ач холбогдлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан “Хийн дасгалын аймгийн аварга шалгаруулах тэмцээн” амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд 18-45 нас, 45-аас дээш насны 2 ангилалд 17 багийн 170 тамирчид оролцлоо. Ахмадын багаас Тэргүүн байр- Иххэт сумын Д.Ширчмаа ахлагчтай “Хэтийн золбоо” баг, Дэд байр Сайншанд сумын Ахмадын хороо Д.Наранцэцэг ахлагчтай “Цоглог” баг, Гутгаар байр-Сайхандулаан сумын Г.Уламбаяр ахлагчтай “Эрч хүч” баг, Залуучуудын ангилалд Тэргүүн байр-Иххэт сумын Э.Долгорсүрэн ахлагчтай “Хэтийн залуус” баг, Дэд байр-АШУҮИС-ийн Г.Цэрэнмядаг ахлагчтай “Анагаах-1” баг, Гутгаар байр Зүүнбаян сумын Б.Шижирмаа ахлагчтай “Намуун урсгал” баг тус тус байр эзэлсэн. Тэмцээний 2 насны ангилалд шилдэг тамирчнаар Иххэт сумын Ч.Галжаргал, Эрдэнэ сумын Т.Батжаргал нар тодорлоо.

Бага насны хүүхдийг ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, 5-11 настай хүүхдийг коронавирусын эсрэг “Комирнэти” вакцинаар дархлаажуулахын ач холбогдлын талаар 600 гаруй НЭМҮТ- 1 сая төгрөг мэдлэг олгох сургалтыг үе шаттайгаар зохион

байгуулж, сургалтыг Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч, клиникийн профессор Ц.Одончимэг удирдан явууллаа. Тус сургалтад өрхийн эрүүл мэндийн төвүүд, хүүхдийн байгууллагын эрхлэгч, захирал, арга зүйч, ОНЭМА, эцэг эхийн төлөөлөл зэрэг нийт 108 хүнийг хамруулан, 5-11 настай хүүхдийг ковид-19 халдвараас сэргийлэх вакцины талаарх 6 төрлийн 314ш гарын авлагыг тараасан. Сургалтын төгсгөлд хүүхдийн дундах ковид-19 халдварын өнөөгийн байдал, 5-11 настай хүүхдийн дархлаажуулалтыг эрчимжүүлэх, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ЭМГ-ын дарга, НЭМТ-ийн дарга, хүүхдийн зөвлөх эмч нар оролцогчдын дунд хэлэлцүүлэг хийснээр үр дүнтэй сургалт боллоо.


“Хүүхдийн дархлаажуулалт–Бяцхан үрсээ халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөг зохион байгуулах удирдамж батлуулан, албан байгууллага, иргэдийг өдөрлөгт оролцохыг уриалан сайтуудад байршуулсан. Өдөрлөгийн үйл ажиллагааг АЗДТГ-ын НБХ-ийн дарга Ч.Байгалтуяа, ЭМГ-ын дарга Г.Энхцэцэг нар эхлүүлж, өдөрлөгт 24 хүүхдийн байгууллага болон бусад байгууллагын ажилчид, иргэд нийт 400 гаруй хүн оролцлоо. Өдөрлөгийн үеэр Аймгийн нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн эмч, чих хамар хоолой, шүдний эмч нар үзлэг хийж, УАУРСТ-ийн уламжлалтын эмч хүүхэд, эцэг эхчүүдэд уламжлалт аргаар дархлаагаа сэргээх тухай зөвлөгөө өглөө. Мөн 3 өрхийн ЭМТ-ийн эмч нар иргэдэд үзлэг хийн, Ковид-19 халдвараас сэргийлэх 5-11 насны хүүхдийн вакцины ач холбогдлын талаар мэдээлэл зөвлөгөө өгч 9 төрлийн 300 гарын авлага тараасан. Эмийн сангууд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, дархлаа сайжруулах витаминь худалдаа, зөвлөгөө өгч хүүхдүүдэд 300 витаминь үнэгүй тараасан. ЭМГ-аас өдөрлөгт оролцсон хүүхдүүдэд 100 витамин, 200 хүчилтөрөгчийн коктейлиор үнэгүй үйлчилж, иргэдэд Ковид-19 халдвараас сэргийлэх, 5-11 насны хүүхдийг дархлаажуулах 2 төрлийн 200 ш зөвлөмжийг тараан, мэдээлэл өглөө.

Цэцэрлэгийн 4 бэлтгэл бүлгийн хүүхдүүд ковид-19 халдвараас сэргийлж гараа сайтар угаах жүжигчилсэн тоглолтыг үе тэнгийн хүүхдүүддээ зориулан хийж, гараа тогтмол угаахыг уриаллаа. Өдөрлөгийн үйл ажиллагааг орон нутгийн телевизрээр нэвтрүүлсэн.5-11 настай хүүхдийг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах 2 төрлийн 455ш зөвлөмжийг хэвлэлийн байгууллагаар хэвлүүлж, үйл ажилагаандаа ашиглалаа.Олон нийтийн эрүүл мэндийн ажилчдааар дамжуулан 7 төрлийн 230 гарын авлагыг олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулан, айл өрхөөр тараасан Аймгийн DTV телевизтэй 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулж гэрээний дагуу 10 сард эмчийн зөвлөгөө-1, Охид хөвгүүдийн цаг нэвтрүүлэг-1,иргэдэд өгөх эрүүл мэндийн зөвлөгөө шторк -5 нийт 7 мэдээллийг телевиз болон цахим сайтаар дамжуулан цацсан.

СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тоолох ажлыг Улсын хэмжээнд эхлүүлээд байна. Тус ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/566 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 09 сарын 14-ний өдөр 14 сумын нутаг дэвсгэрт байрлах түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тоолох зорилгоор Айраг сумаас эхэлсэн билээ. 10 сард Өргөн, Эрдэнэ, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдаар тооллого хийж улсын хэмжээний тооллогын ажил дууссан. Соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаатад авсан газруудыг дүрсжүүлж, бүртгэл хөтөлсөн.

Соёл урлагийн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан "Соёл, урлагийн салбарын ёс зүйн зөвлөл" хуралдаж, 2022 оны сүүлийн улирал болон 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцлээ. Мөн холбогдох хууль эрх зүй, дүрэм журмыг ажилтан албан хаагчдад сурталчлах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан.



“Хү

үхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд аймгийн Засаг даргын А/249 дүгээр захирамжаар батлагдсан "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээнд аймгийн Соёл, Урлагийн газар 5 дугаар сургуулийн 5-7 дугаар ангийн хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулж тэдний санал, хүсэлтийг сонсон хөгжөөнт тэмцээн зохиож, гарын бэлэг гардуулсан.

Төв номын сан болон Өргөн, Эрдэнэ сумдад Зөвлөн туслахаар ажиллаж сайжруулах шаардлагатай ажлуудыг зөвлөмжөөр хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлтийн тайланг хүлээн авсан. Албан хаагчдыг ажлын байран дээр сургах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Соёл, урлагийн газрын мэргэжилтнүүд сургалт мэдээлэл, ярилцлага хэлэлцүүлэг явууллаа. Зөвлөн туслах ажлыг дараах чиглэлээр зохион



байгуулсан.

Монгол улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулагдсан "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ" сургалтад хамрагдсан СУХэлтсийн дарга Б.Хүдэрчулуу эмэгтэй албан хаагчдадаа манлайлал, коучийн ур



чадвар, ажил амьдралын тэнцвэр, төрийн алба ба карьер төлөвлөлтийн талаар сургалт орсон.

Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан “Гэр бүлээрээ” боловсролын хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд байгууллагын захирлын А/24 дүгээр тушаалаар 399,600 төгрөгийг зарцуулсан. Энэхүү боловсролын хөтөлбөр арга хэмжээнд ЕБ-ын сургуулийн 5 сурагч эцэг эхийн хамт оролцож хоол хийсэн. Мөн аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Эрүүл зохистой хооллолт” сэдвээр мэдээлэл 21 хүнд хүргэсэн. Музейн дэргэдэх “Museum shop” ажиллуулж байна. Эсгий гар урлалын, бэлэг дурсгалын зүйлс зэрэг 30-аад бүтээгдэхүүн тавигдсан байна.

Байгууллагын захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар Монгол Улсын Их Сургуулийн Археологийн судалгааны төвтэй хамтран Мандах сумын Өехий багийн нутаг дахь Дэнгийн овоо орчимд археологийн малтлага, судалгааны зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Уг

судалгааны ажилд 6,331,400 төгрөгийг Эрдэм шинжилгээний ажлын зардлаас гарган зарцуулав. Энэхүү археологийн малтлага, судалгааны ажил 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 8 хоногийн хугацаатай үргэлжилж буй бөгөөд өнөөдрийн байдлаар 7 булш малтан судлаж байна.

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Музей сургалт судалгааны төв, МУЭ-ийн Дорноговь аймгийн салбар хамтран “БАГШ-2022” хамтарсан үзэсгэлэн гарч байна. Үзэсгэлэн 1091 сурагчид үзсэн.

Дорноговь аймгаас төрөн гарсан хөгжмийн зохиолч, ая зохиогчид, яруу найрагчдын уран бүтээлийг олон түмэнд сурталчлах түгээн дэлгэрүүлэх, шинэ авьяастнуудыг нээн хөгжүүлэх зорилгоор “Хутагтын говиос эгшиглэсэн аялгуу цадиг” шинэ шилдэг уран бүтээлийн дуун цэнгүүнийг 2022.12.02-нд “Хутагтын шүншигтэй аялгуу” дууны уралдааныг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Төв номын сангаар 10 сарын байдлаар танхимаар 1055, уншигч, ирэгсэд 1213, Танхимаар ном олголт - 1490, гэрээр ном олголт -170 олгож үйлчилсэн. 114 ширхэг ном нааж сэлбэсэн, Уншигчийн карт нээсэн - 55, Зөөврөөр ном олголт 193, Үзэсгэлэнд гаргасан ном -242, “Аз жаргалын өрөө”-нд 85 хүүхэд хамрагдсан. Хэвлэл захиалга 90ш ном, Сэдэвчилсэн лавлагааг 97 удаа өгч уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллалаа.

СУГ-аас ирүүлсэн зөвлөн туслах ажлын хэсгийн удирдамжийн дагуу танхим тасгуудын өдөр тутмын ажлуудыг танилцуулан, номын сангийн бичиг хэргийн ажилтан болон нягтлан бодогч нарт үүрэг даалгаврын зөвлөгөө өгч хамтран ажилласан. Сумдын номын санч нар болон аймгийн төвийн сургуулийн номын санч нарт “Номын сангийн анхан шатны бүртгэл” сэдвээр цахим сургалт явуулсан. Сумдын 18 номын санч сургалтад хамрагдсан. Долоо хоног бүрийн даваа гаригт цахимаар холбогдон хамтын ажиллагааг сайжруулахаар боллоо.

Эрдэнэ сумын Хилийн цэргийн 0129-р ангийн ажилтан, албан хаагч, шинэхэн цэргүүдэд “Номыг шинжихүй” сэдэвт монголын нууц товчооны талаар мэдээлэл хийж нээлтэд нууц товчооны 12 ширхэг хэвлэгдсэн номоор мөн 2022 онд шинээр ирсэн номын дээжээр үзэсгэлэн гаргасан.

ОУ-н багш нарын баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд “Багш бадрахуй” хөтөлбөрийг 10 сарын 1-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Манай төвийн хөтөлбөр аймаг сумдын нийтдээ 24-н Англи хэлний багш хамрагдсан . АНУ-н санхүүжилттэй зохион байгуулагддаг багш нарын болон ахлах ангийн сурагчдын мэргэжил дээшлүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл хүргэсэн.

10 сарын 4-7 ны өдрүүдэд Сайншанд сумын ЕБ-н сургуулиудад 2021 оны FLEX хөтөлбөрийн төгсөгч 5-р сургуулийн сурагч Г.Пүрэвдарьтай хамтран сурагчдад мэдээлэл хүргэлээ. Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагаа болон АНУ-н санхүүжилттэй ахлах ангийн сурагчдын FLEX тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хүсэлт гаргах, тэтгэлгийн эссэг хэрхэн сайн бичих тухай зөвлөгөө өгсөн.

Английн Лийдсийн Их Сургуулийн магистр, доктор, Удирдлагын академийн багш, дэд профессор Ж.Нарантуяа болон түүний охин Канадын Бритиш Колумбын Их Сургуулийн магистр Б.Цэрэнбалжир нар Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжин, өөрсдийн зохиож, орчуулсан англи хэлийг шамдан суралцагсдад нэн шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлагыг хандивласныг Аймгийн Засаг даргын орлогч Г.Март 10 сарын 7-ны өдөр хүлээлгэн өгсөн.

АНУ-н элчин сайдын яамны дэд сайд хадагтай Меласса зочиллоо. 10 сарын 27 ны өдөр сургуулийн сурагчдыг 3 хувааж гурван удаагийн уулзалтыг оюутан сурагчидтай зохион байгууллаа. Оюутны визний төрөл хэрхэн виз мэдүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч сурагчдын хүссэн асуултад хариулж ярилцлаа. Нийт 136 оюутан сурагчид хамрагдсан.

Америкийн Соёл Мэдээллийн төвд нийт 9 дадлагажигч сурагчид 10 сараас эхлэн ажиллаж байна. Бүх сурагчид манай төвөөс явуулж байгаа үйл ажиллагааг хамтран зохион байгуулж байна. Эко говь дахин боловсруулах үйлдвэртэй хамтран сурагч Хүрэлбаатар,

Пүрэвдарь хамтран төсөл бичиж NEXT-GENE төслийн уралдаанд аймгаасаа шалгарч 10 сарын 21-23-нд УБ-т төслийн танилцуулга хийж амжилттай оролцлоо.

Биеийн тамир, спортын газрын жүдо бөх, чөлөөт бөх, бокс, сагсан бөмбөгийн дугуйлан, усан спорт сургалтын төв хэвийн хичээллэн ажиллаж байна.

“Нөхөрлөл лиг” сагсан бөмбөгийн тэмцээн 10 дугаар сарын 04, 11, 18, 25-ны өдрүүдэд тус тус болов.

Улсын Их Хурлын гишүүн, Сайншанд сумын Нутгийн зөвлөлийн тэргүүн Т.Энхтүвшингийн ивээл дор зохион байгуулагдсан ахмадын аймгийн аварга шалгаруулах Сагсан бөмбөгийн тэмцээн 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 10 багийн нийт 100 гаруй ахмад сагсан бөмбөгчид оролцоноос эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрыг “Хайрхан зах” баг, дэд байрыг “Их дэлгэрэх хэт” баг, гутгаар байранд Цагдаагийн газрын баг тамирчид тус тус шалгарсан байна. Эмэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байранд “Их дэлгэрэх хэт” баг, дэд байранд Замын-Үүд сумын баг, гутгаар байранд Сайншанд сумын 2-р багийн баг тамирчид шалгарч алт, мөнгө, хүрэл медалийг хүртлээ.

Аймгийн ҮЭХолбооноос гишүүн байгууллагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Шидэт бөмбөг" гар бөмбөгийн тэмцээн 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Спорт цогцолбор, Спортын ордонд амжилттай болж өндөрлөлөө.

Дорноговь аймгийн Засаг даргын нэрэмжит “Дорноговь цом-2022” боксын тэмцээнд оролцох тамирчдын жин үзэх үйл ажиллагаа 10 дугаар сарын 25-ны өдөр Спорт цогцолборт болов.

Биеийн тамир, спортын улсын хороо нь Монголын хөгжөөн дэмжигч тамирчдын холбоотой хамтран “Хөгжөөн дэмжигчдийн спорт” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 26-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Уг сургалтад Сайншанд сумын 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 11 дүгээр цэцэрлэг, 8 дугаар цэцэрлэг, 5 дугаар сургууль, 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, Дорноговь Политехник коллежийн давхардсан тоогоор 10 багш нар хамрагдлаа.

Хийн дасгалын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 10 дугаар сарын 30-ны өдөр Спорт цогцолборт боллоо.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Өсвөр үе, хүүхдийн хөгжил, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хүүхэд бүхэнд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, хүүхдэд ээлтэй орчин өрөө танхимыг бүрдүүлэх тохижуулах, тус өрөөг үр дүнтэй ашиглах зорилгоор “Хүүхдийн оролцооны байгууллагын өрөө танхимыг тохижуулах” төслийн уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын дунд зохион байгуулсан. Тус уралдаанд:

- Сайншанд сумын ЕБ 3 дугаар сургууль
- Сайншанд сумын Зүүнбаянгийн сургууль
- Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль шалгарч сургууль тус бүрд 3,000,000 төгрөгний санхүүжилтийг олгосон.

Үе тэнгийн сургагч багш нарыг шинээр бэлтгэх, тэдний оролцоог идэвхжүүлэх замаар хүүхэд өсвөр үеийнхэнд Амны хөндий, Хорт зуршил, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Үе тэнгийн сургагч багш” бэлтгэх” сургалтыг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад нийт 46 сурагч хамрагдсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 10 дуудлага мэдээлэл ирсэн. Харьяа хамтарсан багт шилжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Үүнээс 3 кейсийг бүрэн ажиллагаа явуулж шийдвэрлэж хаасан.

Түр хамгаалах байраар хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ авсан 2 хүүхдэд 9 удаагийн гэрийн эргэлт хийж хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг хөдөлгөөнт, явуулын хэлбэрээр газар дээр нь шуурхай үзүүлэх зорилгоор Сайншанд, Улаанбадрах сумдад “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г зохион байгуулж ажилласан. Хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийг мэдлэгжүүлэх хүрээнд 5 төрлийн 700 гарын авлага, тараах материал, 212 эцэг эх, асран хамгаалагчид “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалт, хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах арга хэмжээний хүрээнд 90 өрхөөр гэрийн эргэлт хийж сургууль завсардсан 5, цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 2, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 40 өрхийн 68 хүүхдийг илрүүлж, өрхөд хүнс, амин дэм, бичиг хэрэг, ахуйн хэрэглээний багцыг олгож хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хүргэж ажилласан.

ЕБС-ийн дунд ангийн 86 хүүхэд багачуудад Хүүхэдийн эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, үе тэнгийн дээрэлхэлт, харилцаа хандлага сэдвийн хүрээнд лекц, 34 эцэг эх асран хамгаалагч нарт “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт лекц, ярилцлага, ЕБС, цэцэрлэгийн 15 багш, сурган хүмүүжүүлэгч нарт сурагчдын сэтгэл ханамжийн үнэлгээг танилцуулах, сурган хүмүүжүүлэгч хүний мөрдөж ажиллах ёс зүйн харилцаа, хандлага сэдвийн хүрээнд тус тус лекц, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ арга хэмжээнд нийт 2888,8 мянган төгрөгийг зарцуулсан.

Өсвөр үе залуучуудын нийгмийн идэвхийг сайжруулахад залуучууд өөрсдөө санаачилагатай, манлайлагч байхад суралцах, туршлага судлах, нийгмийн асуудлыг олж харсан залуучуудын шийдлийг танилцуулах, залуучуудын дуу хойлойг сонсох зорилгоор аймгийн залуучуудын “ЗАЛУУС+ОРОЛЦОО=ӨӨРЧЛӨЛТ” нэгдсэн чуулган 10 сарын 29-ний бямба гарагт “Саран хөхөө” театрт зохион байгуулагдлаа.

Чуулганаар

- “Залуучууд+Оролцоо=Өөрчлөлт”
- “Залуучуудын санаачилга+манлайлал=Өөрчлөлт”
- “Залуучууд ба зохистой хөдөлмөр”
- “Европын холбоон дахь боломжууд” гэсэн 4 үндсэн сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлэг явагдаж 14 сумын төлөөлөл 200 гаруй залуучууд оролцож үзэл бодлоо илэрхийллээ.

Илтгэлүүдийг Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Урьболд, “Старт-ап Монгол” ТББ-ын Дэд ерөнхийлөгч, “Нито” ххк үйл ажиллагаа хариуцсан захирал З.Уянга, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга Э. Тамир, Европын холбооны санхүүжилттэй “Бүгд Залуусын төлөө Залуус бүгдийн төлөө төслийн менежер Н.Мөнхчимэг нар илтгэл тавьж Дорноговийн түүчээлэгч залуус өөрийн туршлагаасаа хуваалцлаа.

Nextgen Залуучуудын санал санаачилгыг дэмжсэн нийгмийн төслийн уралдааны 3-р шатны шалгаруулалтад Дорноговь аймгаас 3 нийгмийн төсөл оролцсоноос “Ардыно Робот” хүүхэд залуучуудад техник сэтгэлгээ суулгах, удирдлагатай машин хийх, код бичих сургалтын төсөл шалгарч 20 сая төгрөгний санхүүжилт авахаар боллоо. Мөн Нэкстжений анхан шатны шалгаруулалтад оролцсон 9 залууг DEMO DAY төсөл хэрхэн бичих, төслийг хэрхэн шалгаруулдаг, шинэ инновацлаг санааг хэрхэн олох талын сургалтад хамруулж Мон-Икс нийгмийн төслийн мэдээллийг хүргэж ажилласан.

Нийгэмд эерэг хандлага уриалсан, сайн дурын ажлыг зохион байгуулж буй хүүхэд, залуучууд, байгууллага хамт олны сайн туршлагыг хуваалцах, тэдний үйл хэргийг олон нийтэд сурталчлах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй "Нэг хамт олон-Нэг сайн дурын ажил" арга хэмжээний хүрээнд 14 сумын 33 хамт олон залуусын нэгдэл сайн дурын ажил хийсэн тайлангаа ирүүлсэнийг байгууллагын цахим хуудсанд тавьж сурталчлан ажиллалаа.

Охидын өдрийн тохиолдуулан "Одоо бидний цаг, бидний эрх, бидний ирээдүй" хэлэлцүүлгийг зохион байгуулж, Сайншанд сумын ЕБ 4 сургууль, Политехникийн коллежийн 120 охид, хөвгүүдийн төлөөлөл оролцон "Насанд хүрэгчдэд өгөх зөвлөгөө", "Үе тэнгийнхэндээ өгөх зөвлөгөө", "Дүү нартаа өгөх зөвлөгөө", "Одоо бидний цаг ..." 4 сэдвийн хүрээнд хэлэлцэн зөвлөмж гаргалаа. Хэлэлцүүлэгт оролцогчдод Цагдаагийн газар, аймгийн ЗДТГ, ГБХЗГ-ын холбогдох албан тушаалтнууд мэдээлэл өгч, харилцан санал солилцлоо.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Замын-Үүд сумын 3-р сургууль дээр, 10 сарын 18-21-ний өдрүүдэд Сайншанд 2-р сургууль дээр Боловсролын чанарын үнэлгээний шалгалт, судалгааг зохион байгууллаа. Үүнд: Чанарын үнэлгээний шалгалтад хамрагдсан нийт 180 сурагч, тус сурагчдын 15 эцэг эх, мөн тухайн сурагчдад хичээл зааж байсан монгол хэл, математик, хими, биологи, физик, газарзүйн 13 багш, 2 удирдах ажилтантайгаа цахимаар асуулгад хамрагдав. 1-р ангийн монгол хэл, 11-р ангийн физик, 9-р ангийн биологийн багш нарын хичээлд тус тус сууж ажиглалт хийн тэмдэглэл хөтөлсөн. тус сургуулийн гадаад, дотоод орчин, лаборатори, кабинетуудад асуумжын дагуу орчны үнэлгээ хийсэн. Хими, биологи, физик, бага ангийн монгол хэл, математикийн хичээлийн нийт 5 багштай фокус ярилцлага хийн тэмдэглэсэн. Дунд ангийн сургалтын менежертэй ярилцаж асуумж судалгаа бөглөсөн. Эдгээрийг chanag.asuulga.eec.mn сайтад нэг бүрчлэн шивж оруулсан.

БҮТ, БШУЯамнаас хамтран зохион байгуулсан "Боловсролын салбар дахь гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ" сэдэвт хэлэлцүүлэгт 3 албан хаагч оролцуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн А/280 дугаар тушаалд үндэслэсэн "Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх" үнэлгээг зохион байгуулж, тайланг нэгтгэн илгээлээ.

"Дотуур байрын суралцагчийн эрх хамгаалал, аюулгүй байдал" үндэсний сургалт, уулзалт хэлэлцүүлэг 18 аймаг, Нийслэлд нэгэн зэрэг үргэлжилж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний" дагуу 4.2.1.3-д заасны дагуу БСҮХ-ийн Гадаад хэлний төв, Боловсролын ерөнхий газар, аймаг нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран 2022-2023 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдад зориулсан "АНГЛИ ХЭЛНИЙ ЗӨВЛӨГЧ СУРАГЧ" хөтөлбөрт ЕБ-ын тавдугаар сургууль тэнцлээ.

БШУЯ, БЕГ, БШУГ-ын хамтарсан цахим уулзалт болж өндөрлөсөн ба 21 аймаг 9 дүүргээс нийт 100 гаруй хүн сургалтанд хамрагдаж Боловсролын салбарын төсөвт тулгарч байгаа асуудлын талаар дэлгэрэнгүй санал солилцож асуудлыг шийдвэрлэн ажилласан.

"Аймгийн Засаг даргад илгээх миний захидал"-ын үйл ажиллагаа аймгийн 20 сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдаж дууслаа.

Аймгийн хэмжээнд 21 сургууль, 36 цэцэрлэг болон шинээр томилогдсон захирал эрхлэгч нартай Боловсролын салбарын төсвийн шинэчлэл ба хэрэгжилтийн явцын талаар сургалт уулзалтыг зохион байгуулж нэгдсэн чиглэл өгч ажилласан.

Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, НТБ, СӨБ-ын аргазүйчдийг чадваржуулах, тэгш хамран сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой 2 өдрийн сургалтыг зохион байгуулж байна.

Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1, 3-р сургуулийн үдийн хоолны үйл ажиллагаатай танилцан зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Америкийн соёл мэдээллийн төвийн ажилтантай хамтран Аймгийн төвийн 1,2,3,5-р сургуулийн 9-11-р ангийн сурагчдад Америкийн соёл мэдээллийн төвийн хөтөлбөр болон АНУ-ын засгийн газрын хөтөлбөртэй FLEX хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Зүүнбаян, Эрдэнэ сумдын ЕБС-ийн бага ангид хэрэгжиж буй “Тоглонгоо суралцъя” үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй “Үсэг үе үг унших”, “Өгүүлбэр унших”, “Эхтэй ажиллах”, “Арифметик үйлдэл”, “Өгүүлбэртэй бодлого бодох” дугуйлангуудын үйл ажиллагаатай танилцаж, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн өмчийн 20 сургуулийн хими биологийн багш нарт AR төхөөрөмжийг ашиглах мөн Сургалтад ухаалаг утсыг ашиглах аргазүй сургалтыг зохион байгуулсан.

Боловсролын салбарын ёс зүйн жилийн хүрээнд багшийн андгай өргөх үйл ажиллагааг зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын 200 багш, ЕБС-ийн 600 орчим багш оролцлоо.

Аймгийн хэмжээнд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Боловсролын Ерөнхий Газарт 05-ны өдрийн дотор 01 дүгээр сараас 09 дүгээр сарыг хүртэл өссөн дүнгээр 26,297,358,500 /Хорин зургаан тэрбум хоёр зуун ерэн долоон сая гурван зуун тавин найман мянга таван зуун төгрөг /-ийн улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авч гүйцэтгэл 21,542,912,000 /Хорин нэгэн сая таван зуун дөчин хоёр сая есөн зуун арван хоёр төгрөг/-ийн гүйцэтгэлтэй мэдээг баталгаажуулж нийт аймгийн хэмжээнд 55 байгууллага хамрагдсан.

Аймгийн хэмжээнд бүх цэцэрлэг сургуулийн 10 дугаар сарын Хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгааг нэгтгэж тооцооллыг Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн.

Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй “Хүүхдийн дархлаажуулалт-Бяцхан үрсээ халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөгт Сайншандын төвийн цэцэрлэгүүдийн Бэлтгэл бүлгийн хүүхдүүд оролцож чих хамар хоолой, шүдний үзлэгт хамрагдсан. Мөн “Ковид-19 халдварын эсрэг вакцинаар 5-11 насны хүүхдийг дархлаажуулахын ач холбогдол” сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, эмч, арга зүйч нар хамрагдсан.

Орон нутгийн хэмжээд шинжлэх ухаан, технологи, инновацийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, ололт амжилтуудыг илрүүлэх, Мон-Х Prize хөтөлбөрийг танилцуулах ажлын хүрээнд ХХААГ, Мал эмнэлэг, ХХҮГ, ЕБ-ын 2, 5 дугаар сургууль, Политехник коллеж, гар урлалын Эсгий урлан зэрэг үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуй нэгжүүдэд очиж төсөл хөтөлбөр зохион байгууллаа.

Аймгийн нийт Гадаад хэлний багш нар суралцахууд суурилсан Мэргэжлийн хөгжлийн 5 бүлэгт хуваагдан энэ хичээлийн жилд хамтарч явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэлэлцэн гаргав.

Сайншандын сумын ЕБ-ын 1,2,3,5-р сургуулийн Англи хэлээр ЭЕШ өгөх суралцагчдад 10 сарын 29,30-ны өдрүүдэд Улаанбаатар хотоос Ч.Дэлгэрмөрөн багш ирж сургалт явууллаа.

Иххэт суманд “Бага ангийн сурагчдын унших, бодох” чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслахаар ажилласан.

21 сургуулийн 2-5 дугаар ангийн сурагчдаас Унших чадварын түвшинг тогтоолоо.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

1.Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- 2022 оны 10-р сард орон нутгийн төсөвт 67,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс орон нутгийн төсөвт 39,2 тэрбум төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөө 57,8 %-ийн биелэлттэй байна.

- Шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад сар бүрийн 8-ний дотор нийт 93 байгууллагын мэдээлэлд хяналт хийж хугацаанд нь бүрэн оруулсан. Нийт төсөв хөрөнгөтэй холбоотой 31 захирамж байршуулсан.

- Орон нутгийн байгууллагад - 700,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтад – 2,8 тэр бум төгрөгийн санхүүжилт олгосон.

- Улсын төсвийн байгууллагын байр ашиглалтын зардалд - 1,1 тэрбум санхүүжилт олгосон.
- ТЕЗ-н 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайланг нэгтгэж сангийн яаманд цахимаар нэгтгүүлсэн.
- Номин даатгал болон Монгол даатгалын компаниудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэнээс аймгийн Засаг даргын Тамгын газарт хандан өргөдөл, гомдол ирсэнийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, Зохицуулалтын газарт албан бичгээр хандаж холбогдох хариуг гомдол гаргасан иргэд хүргүүлсэн.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2022 оны 10 сарын 1-30-ний хооронд нийт 2153 гүйлгээний 11983.6 сая төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

2. “Цаг үеийн ажлын мэдээлэл”

- Сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 11 сумын 24 ажлын 1,2 тэрбум төгрөгний санхүүжилтийг анхан шатны баримтыг үндэслэн олгосон.
- Нэмэлт санхүүжилтийн 45 байгууллагын хүсэлтийг үндэслэн 251,5 сая төгрөгийн хүсэлтийг үндэслэн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- E-Huulga цахим программд хуулга харах эрх нээлгэх хүсэлт ирүүлсэн 6 байгууллагын хүсэлтийг шийдвэрлэж ажилласан.
- Ахмадын сангийн төсвийн зарцуулалтын эрх нээлгэх 15 байгууллагын хүсэлтийг үндэслэн 20,6 сая төгрөгийн төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлж ажилласан.
- 2023 оны төсвийн төсөл боловсруулах бэлтгэл хангаж цалин хөлсний болон тогтмол зардлын судалгаа гаргах ажлыг хийж байна.
- Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн аймагт шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ажиллах амьдрах таатай нөхцөл бүрдүүлэх богино хугацааны төлөвлөгөө гаргаж ажилласан.
- Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Үнэт цаасны зах зээл” сэдэвт орон нутгийн төлөөлөгчид зориулсан сургалтанд хамрагдсан
- Сангийн яам Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтортой байдлыг бэхжүүлэх төслийн дэмжлэгтэйгээр Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг цаашид тогтвортой, хэвийн ажиллагааг хангах зөвлөгөө, дэмжлэгийг харьяа төсвийн байгууллагуудад өгч ажиллаж байна.
- Хөвсгөл сумын ЕБС, хүүхдийн цэцэрлэг, Мандах сумын ИТХ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу ахмадын сангийн данс нээлгэх албан бичгийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын хэлтэс:

1. “Цаг үеийн ажлын мэдээлэл”

- Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны төлөвлөгөө, албаны даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын 14 дүгээр

- цэцэрлэгийн 2020, 2021 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж дуусгасан.
- Албаны даргын баталсан 11 тоот удирдамжийн дагуу Хатанбулаг сумын төсөвт байгууллагуудын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын нэгдсэн акт, тэмдэглэлийг нэгтгэж байна.
 - Монголын Улсын Сангийн сайдын баталсан удирдамж, албаны даргын 113 тоот удирдамжийн дагуу Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, усны үнийн дүнгийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой тухайн үйлчилгээг үзүүлсэн аж ахуйн нэгжийн төрөөс нэхэмжилсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн төлбөр тооцооны байдалд хяналт, шалгалтыг эхлүүлээд байна.
 - Албаны даргын баталсан 14 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.
 - Албаны даргын баталсан 15 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг эхлүүлээд байна.
 - Актын төлбөрийн барагдуулалтаар 3645,5 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлсэн.

Статистикийн хэлтэс:

1. Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 09 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, 600 гаруй хэрэглэгчдэд цахим болон хэвлэмэлээр тархааж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулсан. Мөн орон нутгийн телевизтэй хамтран иргэд, олон нийтэд хүргэсэн.
- Долоо хоног бүрийн даваа гаригт судалдаг гол нэр төрлийн 32 нэр төрөл, нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивж, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуусан.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зоогийн газрын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗГ-1/, зочид буудлын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗБ-1/, худалдааны сарын мэдээ /ХУ-1/, худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ/ХСҮ/, авто усан замын тээврийн улирлын мэдээ/Т-1/, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, хөдөө аж ахуйн /ХАА-3, ХАА-8, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан нэгтгэн программд шивж дамжуулсан. Төрийн бус байгууллагын улирлын мэдээ/ТББ/, барилга байгууламж, объектийн улирлын мэдээ /ББО/, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг улирлын мэдээ /АЖ/-г графикт хугацаанд нь дамжуулан ажилласан.
- Өрхийн нийгэм, эдийн засаг, ажиллах хүчний 10-р сарын судалгаанд Замын-Үүд, Дэлгэрэх, Иххэт, Даланжаргалан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг

Сайншанд сумдын 128 өрхийг хамруулж, мэдээлийг бүрэн цуглуулж, боловсруулан ҮСХ-д дамжуулж байна.

- Дорноговь аймаг дахь төрийн Аудитын газрын албан хаагчдад зориулан “Статистикийн үйл ажиллагаа, статистик мэдээллийг хэрхэн ашиглах нь” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

- Улс ба орон нутгийн төсөвт 3537,9 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 7 төрлийн нийт 3,683 татварын тайлан, 625 хүсэлтийг хүлээн авч ажилласан. Тайлант сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 685, өрөөгөөр 421 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийж үйлчилгээ үзүүлсэн.
- Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 12 хуулийн этгээдийн мэдээллийг баазад бүртгэж ажиллалаа. НӨАТ суутган төлөгчөөр 7 хуулийн этгээдийг бүртгүүлсэн.
- Татвар төлөгчдөөс 1800-1288 тусгай дугаарт 80 гомдол ирсэнийг холбогдох албан хаагчдад хуваарилж, 112 гомдлыг шийдвэрлэсэн.

Төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй сургалт, сурталчилгааны биелэлт

- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 2022.10.11-ний өдөр зохион байгуулсан санхүүгийн дэмжлэгт үр ашгийг хүртэгчидтэй уулзах уулзалт, арга хэмжээнд оролцож хувиараа бизнес эрхэлдэг 45 татвар төлөгчдөд ХХОАТ-н тухай хуулиар мэдээлэл хийж холбогдох асуултад хариулт өгч ажилласан.
- Дорноговь аймгийн багийн Засаг дарга нарыг чадавхжуулах "ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ" сэдэвт сургалтад Төсвийн орлого бүрдүүлэлтэд багийн Засаг даргын үүрэг, оролцооны талаар мэдээлэл хийсэн.
- Чандмань илч ОНӨХХК-ийн 116 ажилчдад 2022.10.17-ны өдөр ХХОАТ-н хөнгөлөлт чөлөөлөлт, буцаан олголтын талаар мэдээлэл хийж зөвөлгөө өгч ажилласан.
- Шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдэд зориулсан сургалтыг 2022.10.27-ны өдөр зохион байгуулж 48 татвар төлөгчийг хамруулсан.

Орон нутгийн өмчийн газар :

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

Худалдан авах ажиллагаа

- Сайншанд суманд түрээсийн орон сууц хэрэгжүүлэх ажил, Сайншанд сумын 3, 4-р 58 айлын гадна авто зогсоол барих ажил, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах ажлуудын тендерийг зарласан.
- Тендер зохион байгуулагдаж гүйцэтгэгч шалгарсан 24 төсөл арга хэмжээний архивын баримт бичгийг боловсруулсан.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг зохион байгуулж дүн мэдээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нэгтгүүлсэн.

ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт
Нэг. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр:		
1	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтлөх, удирдлагуудад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж 2 (2022.10.04-ний өдрийн 157 дугаартай "Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, цогц арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах тухай захирамж, мөн өдрийн 156 дугаартай Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг хариуцсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай захирамж)</p> <p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 1 (2022.10.05-ны өдрийн 358 дугаартай "Хилийн боомтын захиргааны зохион байгуулалтын бүтэц"-ийг шинэчлэн батлах тухай тогтоол)</p> <p>Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 4 (2022.09.22-ны өдрийн 46 дугаар тэмдэглэл, 2022.10.05-ны өдрийн 48 дугаар тэмдэглэл, 2022.09.28-ны өдрийн 47 дугаар тэмдэглэл, 2022.10.10-ны өдрийн 49 дугаар тэмдэглэл)</p> <p>Аймгийн ИТХ-ын тогтоол 2 (2022.10.18-ны өдрийн 09/02, 09/05 дугаартай тогтоол) зэрэг нийт 9 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтлөн удирдлагуудад танилцуулсан.</p>
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:		
2	Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй дэд болон зорилтот хөтөлбөрийн судалгаа гаргах	Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй 13 дэд хөтөлбөрийн судалгааг нэгтгэн, ЗДТГ-ын даргаар тайлагнах хуваарийг батлуулан, хэлтсүүдэд хяналтад өгсөн. Аймгийн ИТХ-аар 12 сард оруулан үнэлүүлэх тул хэрэгжилтийг 11 сарын 15-наас авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
3	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/280 дугаар захирамжийг шинэчлэн батлах тухай баримт бичгийн төсөл, аргачлалын төслийн танилцуулгыг бэлтгэн, удирдлагын түвшинд болон агентлагийн дарга нарын хуралд танилцуулсан.

	захирамжийг шинэчлэн баталгаажуулах	
4	Агентлаг, сумдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж дүгнэлт хүргүүлэх	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, ажлын байран дээрх мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. 2019-2021 онд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж үзэхэд ХХААГ-ын үйл ажиллагаа хангалтгүй байсан тул хариуцлага тооцох санал, БОАЖГ-ын үйл ажиллагаа эрчимжүүлэх шаардлагатай байсан тул сануулах арга хэмжээ авахыг Засаг даргад уламжилсан. Дүгнэлтийг зөвлөмжийг нэгтгэн, ЗДТГ-ын даргад хянуулахаар хүргүүлсэн.
5	Дээд шатны байгууллагаас ирсэн тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын нэгдсэн судалгааг гарган, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	Дээд шатны байгууллагаас ирсэн тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын нэгдсэн судалгааг 2022.10.14-ний өдрийн байдлаар нэгтгэн гаргахад 114 тогтоол шийдвэр ирсэн байна. Нийт тогтоол шийдвэрийг удирдлага болон бусад хэлтсүүдэд танилцуулж, хяналтдаа аван хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлэн ажилласан.
6	Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа хийх гэрээг байгуулан санал асуулгыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих	Дорноговь аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлчилгээний газрын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг 2000 иргэнээс авахаар гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн.
7	АЗДТГ-ын мэргэжилтнүүдэд ХШҮ-ний чиглэлээр сургалт зохион байгуулах	ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Цаг үеийн ажлуудаас болоод сургалтаа зохион байгуулж амжаагүй.
<i>Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр:</i>		
8	Шинээр томилогдсон болон албан тушаал өөрчлөгдсөн албан хаагчдын судалгааг гаргах, хяналт-шинжилгээний үнэлгээний цахим санд ажиллах эрх нээлгэх	Мэргэжлийн хяналтын газрын 1, Боловсрол, шинжлэх ухааны газрын 6, Алтанширээ сумын 1, Соёл урлагийн газрын 6, Номын сангийн 1, Даланжаргалан сумын 4, Орон нутгийн өмчийн газрын 1, Сайншанд сумын 6, Захирагчийн албаны 2, Сайхан дулаан сумын 1, Уламбадрах сумын 3, Мандах сумын 3, Мандах сумын Соёлын төвийн 1, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 3, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2, Хөвсгөл сумын 5 шинэ мэргэжилтэн нийт 47 албан хаагчдын мэдээллийг "Ухаалаг засаглал ТББ"-руу илгээж, нэвтрэх, тайлагнах эрхийг үүсгэсэн.
<i>Дөрөв. Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:</i>		
9	Хэлтсийн сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлж ажиллах	Хэлтсийн 7 сарын төлөвлөгөөг боловсруулан, ЗДТГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хяналтад авч ажилласан. 7 хоног бүрийн тайланг нэгтгэн, хамт олны мэдээллийн цагаар танилцуулсан. Сарын тайланг

		нэгтгэн, ТЗУХ-т хүргүүлсэн
10	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг шуурхай хийж гүйцэтгэх	<p>ХШҮ-ний цахим санд Ерөнхий сайдын шуурхай 1 үүрэг даалгаврын 6 заалт орсныг хариуцах хэлтсүүдэд хуваарилсан.</p> <p>Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа дахь Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн чиг үүргийн тухай танилцуулгыг бэлтгэсэн.</p> <p>Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/649 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсгийн холбогдох чиг үүргийн төлөвлөлтийг боловсруулсан..</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлангийн 29 арга хэмжээ, Засгийн газрын үйл ажиллагааны 18 заалт арга хэмжээ цахим санд орсныг хуваарилан, хэрэгжилтийг гаргаж ирүүлэхийг хэлтсүүдэд чиглэл болгон өгсөн.</p>
11	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, ирсэн албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх	<p>Дорноговь аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хэсэг дэх эрх зүйн актыг хяналтад авч, хуваарилах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.</p> <p>Хэлтэст шинээр албан бичиг ирээгүй.</p>